

СОЁМБОМЭДЭЭ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД АХМАД ДАЙЧДЫН ХАМТ “ТУСГААР ТОГТНОЛ” УРАН БҮТЭЭЛД ДҮРЭЭ МӨНХӨЛНӨ



Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын уран зохиолч Дэндэвийн Пүрэвдоржийн “Тусгаар тогтнол” шүлэг бол Монгол хүн бүрийн бахархал, бишрэлийг төрүүлсэн үндэсний хэмжээний томоохон уран бүтээлүүдийн нэг. Энэ л шүлгээ Монголын ард түмэн хэдэн арван жил уншиж тусгаар тогтносон улсын иргэн гэдгээрээ омогшиж ирсэн. Тэр тусмаа энэ шүлэг Ардын

хувьсгал, Үндэсний их баяр наадмын өдрүүдэд Монгол хүн бүрийн цөсийг хөөргөж чадах уран бүтээл гэж хэлж болно. Тэгвэл тус шүлгээр сэдэвлэсэн “Тусгаар тогтнол” цуврал нэвтрүүлгийг “Боловсрол” телевизийн уран бүтээлчид бэлтгэн үзэгчийн хүртээл болгохоор ажиллаж байна.

Мөн тус шүлгийн 4 бадагт “Никитон” хамтлагийн ахлагч, хөгжмийн зохиолч, төгөлдөр хуурч, Урлагийн гавьяат

зүтгэлтэн Б.Батчулуун ая хийж, Чингис хааны одонт, МУГЖ дуучин Г.Ариунбаатар дуулж үзэгчдийн хүртээл болгох юм. Тус уран бүтээлийг дүрсжүүлэхэд Батлан хамгаалах салбарын оролцоо багагүй бөгөөд дайнд оролцсон ахмад дайчдыг ч дүрс бичлэгт оролцуулав. Тухайлбал, 1945 оны Чөлөөлөх дайн, 1948 оны Баруун хилийн тулгаралтад оролцож

явсан ахмад дайчид болох С.Лувсан-Очир, У.Доржпалам, С.Чимэддорж, Б.Рагчаа, Ц.Чимэдцэрэн, Г.Баарай, Т.Батсуурь нарыг Батлан хамгаалахын сайд хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээгээр тус уран бүтээлийг дүрсжүүлж байгаа юм.

Энэ талаар Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр “Эх орныхоо төлөө залуу нас, халуун цусаа зориулсан ахмадуудтайгаа хамт эх орны сэдэвт уран бүтээлд дүрээ мөнхөлж байгаадаа баяртай байна. Энэ бол эх орны үнэ цэнэ, тусгаар улсын билэг тэмдэг болсон уран бүтээл юм. Нөгөөтэйгөөр уг уран бүтээл бол тусгаар улсын төлөө тулалдаж явсан та бүгдэд зориулж байгаа залуу үеийнхний бэлэг гэж хэлж болно. Тиймээс ийм сайхан уран бүтээлийн санаачлан хэрэгжүүлж байгаа “Боловсрол” суваг телевизийнхэн болон урлагийн сор болон гялалзаж яваа залуу уран бүтээлчид та бүхэнд ахмад дайчдынхаа нэрийн өмнөөс баярлаж буйгаа илэрхийлье” гэв.

Сонируулахад, Ардын хувьсгалын 100, Үндэсний их баяр наадамд зориулсан “Тусгаар тогтнол” цуврал нэвтрүүлэг 7 удаагийн тусгай дугаартай ба ирэх 7 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн 20 цагт 45 минутын хугацаатайгаар “Боловсрол” суваг телевизээр цацагдах аж.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
11	7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	24

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
29	16

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.844.00	2.855.00
EUR	3.73.00	3.433.00
CNY	490.00	443.20
RUB	38.90	40.50
JPY	25.44	25.93
KRW	2.44	2.57

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН
2021.06.29.
/МЯГМАР ГАРАГ/

ЧӨДӨР ОДТОЙ, НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ, ШАР БИЧ ӨДӨР

Үс засуулбал:

Өлсөж ундаасна

Наран ургах, шингэх:

4.56 -20.55

Барилдлага:

Түлэх

Шүтэн барилдлага:

Хуран үйшлэдэхүй

Суудал:

Ус

Өнөөдөр аргын тооллын 2021 оны зургаадугаар сарын 29. Мягмар гараг. Билгийн тооллын XVII Жарны “Цөөвөр” хэмээх Цагаагчин төмөр үхэр жилийн Зуны дунд хөх морь сарын шинийн 20. Ангараг гараг. Чөдөр одтой, найман цагаан мэнгэтэй, шар бич өдөр. Өдрийн наран 4 цаг 56 минутад мандан, 20 цаг 55 минутад жаргана. Тухайн өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, сан тавиулах, угаал үйлдэх, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, хур оруулах, дархны үйлд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлэх буюу засуулахад тохиромжгүй бөгөөд өлсөж ундаасна хэмээжээ.

ОХУ-ЫН ЦЭРГИЙН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Улсын Ерөнхий прокуратурын газрын урилгаар Монгол Улсад ажлын айлчлал хийж байгаа ОХУ-ын Цэргийн Ерөнхий прокуратурын бүрэлдэхүүнийг ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг өчигдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтаар ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг “Аль ч улсын Зэвсэгт хүчинд бие бүрэлдэхүүн хамгаас чухал. Та бүхний үйл ажиллагаа энэ чиглэлд асар их ач

холбогдолтой. 1993 онд манайх Цэргийн прокуратурын газраа татан буулгасан. Бид эргэн сэргээхийг хүсэж байгаа бөгөөд энэ талаар Ерөнхий прокуратурын газартай үр дүнтэй харилцаа тогтоохыг хичээж байгаа. Оросын Цэргийн прокуратурын ерөнхий газар Зэвсэгт хүчнийхээ сахилга бат, дэг журмыг хариуцдаг гэдгийг сайн мэднэ. Мөн энэ хүрээнд та бүхэн манай улсын холбогдох байгууллагуудтай сургалт явуулж байгаад талархаж байна.”

Цэргийнхнийг цэргийн прокурор л сайн ойлгоно” хэмээн хэлсэн бол үүний хариуд ОХУ-ын Ерөнхий прокуратурын орлогч, Цэргийн ерөнхий прокурор В.Г.Петров “Манай хоёр улсыг найрамдалт харилцаа нь холбож байдаг. Энэхүү найрамдал, нөхөрлөл Халх голд дайсныг ялахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Өчигдөр ОХУ-ын Элчин сайд Азизовтой ярилцахад Халх голын тухай кино хийж байгаа тухай бидэнд мэдээлсэн. Мөнгө санхүүгийн хувьд жаахан бэрхшээлтэй байгаа гэж байна. Миний бие эргэж очоод ивээн тэтгэгч хайх ажилд туслах бодолтой байна. Манай хоёр улсын түүхт хамтын ажиллагаа Дэлхийн хоёрдугаар дайны үед батажсан. Танай улс, ялангуяа Монгол Улсын Зэвсэгт хүчин түрэмгийлэгчидтэй тэмцэхэд тусалж, найдвартай ар тал болж байсан. Монголчуудын хөрөнгөөр байгуулсан “Хувьсгалт Монгол” танкны бригад Берлин хүрсэн. Монголоос нийлүүлж байсан арьс үс, ширэн бүтээгдэхүүн ихээхэн алдартай байлаа. ЗХУ-ын үед танайд манай олон мэргэжилтэн ажиллаж байсан. Сүүлийн үед хоёр орны харилцаа хөгжиж байгаа бөгөөд боловсон хүчин бэлтгэх гээд бүх талаар туслахад бид бэлэн байна. Мөн өөрийн харьяаны сургуулиудад эрдмийн зэрэг цол хамгаалуулах талаар ч дэмжлэг үзүүлж болно”

гэдгээ илэрхийлсэн юм.

Тус уулзалтын дараа “Цэргийн албаны эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэх, ажиллагааны онцлог, урьдчилан сэргийлэх ажил” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад БХЯ-ны хуулийн зөвлөх, хурандаа Г.Энхболд, Улсын Ерөнхий прокуратурын орлогч, төрийн хууль цаазын шадар туслах М.Чинбат, ОХУ-ын Ерөнхий прокуратурын орлогч, Цэргийн Ерөнхий прокурор В.Г.Петров болон ЗХЖШ, Төрийн цэргийн командлал болон Зэвсэгт хүчний нэгтгэл анги, ХХЕГ-ын холбогдох албан тушаалтан, хуулийн офицерууд оролцож, ОХУ болон Улсын Ерөнхий прокуратурын газрын холбогдох албан тушаалтнууд “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг, шийдвэрлэх байдал”, “Шүүхийн өмнөх шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь цэргийн прокуратурын ажилналт” сэдвээр хичээл явуулсан юм.

Уулзалтад ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ц.Жавхланбаатар, БХЯ-ны хуулийн зөвлөх, хурандаа Г.Энхболд, ЦХАХ-ийн дарга, хурандаа Н.Нямжаргал, ОХУ-ын Ерөнхий прокуратурын орлогч, Цэргийн Ерөнхий прокурор П.В.Георгиевич, Дорнын цэргийн тойргийн прокурор, дэслэгч генерал З.С.Александривич болон албаны бусад хүмүүс байлцлаа.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

111.505

ЭДГЭРСЭН

70.792

НАС БАРСАН

533/15

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

3338(58)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

340

ЭДГЭРСЭН

2938

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 181,047,252

Эдгэрсэн

Нийт:

Нас барсан

Нийт: 3,922,087



СЭРЭМЖЛҮҮЛЭГ



Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 14 дүгээр хорооноос илэрсэн 100 мм-ийн Д-10 их бууны сум 2017 оны 5 дугаар сар

Сүүлийн үед манай улсын зарим нутаг дэвсгэрт байлдааны болон сургуулийн зориулалттай төрөл бүрийн гранат, сум, мина зэрэг тэсэрч дэлбэрэх зүйлс илрэх үзэгдэл элбэг тохиолдож байна. Тодруулбал, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Ховд зэрэг аймаг болон нийслэлийн Багануур, Багахангай дүүрэгт өмнө нь цэргийн зориулалтаар ашиглагдаж байсан эдгээр зүйлс нь олон жил газарт булагдаж, зэвэрч хуучирсан, чанар байдал нь муудсан эсвэл нар салхинд элэгдэж, хэт мэдрэмтгий шинж чанартай болсноос аюултай эсэхийг нь таних, илрүүлэх, хөдөлгөх, хөндөх болон тээвэрлэхэд маш аюултай нөхцөлийг бий болгож байна.

Иймээс тухайн аймаг, орон нутаг, дүүрэгт оршин суух иргэд, хүүхэд залуучуудын зүгээс тэдгээр аюултай зүйлсийг таньж мэдээгүйн улмаас эсвэл мэдсэн ч хайхрамжгүй хандсанаас тэдгээр тэсэрч дэлбэрэх аюул бүхий эд зүйлийг ахуйн хэрэгцээндээ ашиглаж, зэс, гууль, хөнгөн цагаан зэргийг нь авах оролдлогыг хийж байна. Ингэснээр өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хохироох, гэмтэл учруулах, мал, амьтан, эд хөрөнгөө эрсдэлд оруулах аюултай нөхцөл үүсдэг. Зөвхөн өнгөрсөн жил гаруйн хугацаанд Зэвсэгт хүчин ангиудын орон тооны болон орон тооны бус тэсэрч дэлбэрэх зүйлийн хайгуул, устгалын бүлэг нь их, бага калибрын

буудлагын зэвсгийн сум, галт хэрэглэл, төрөл бүрийн гранат зэргийг олноор нь илрүүлж, тэдгээрийг устгах, аюулгүй болгох ажлыг хэрэгжүүлсэн юм. Иймд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд хэрэв цэргийн зориулалттай тэсэрч, дэлбэрэх зүйлийг олсон, илрүүлсэн эсвэл байж болзошгүй гэж үзвэл холбогдох дүрэм журмын дагуу уг зүйлийг хөндөх, хөдөлгөхийг хатуу хориглох бөгөөд тухайн газар оронд аль болох хүн, мал, амьтныг ойртуулахгүйгээр тэмдэглэн яаралтай цагдаагийн байгууллагад мэдэгдэж, улмаар мэргэжлийн бүлгийн бүрэлдэхүүнийг иртэл хамгаалалтад авахуулах шаардлагатай байгааг хатуу анхааруулъя.

АРИУТГАЛ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТИЙГ ТОГТМОЛ ЯВУУЛЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 327 дугаар анги



"Ковид-19" цар тахлын халдваруулсын хэмжээнд төдийгүй Дорнод аймагт буурахгүй байгаатай холбогдуулан Зэвсэгт хүчний 327 дугаар ангиас халдвараас урьдчилан сэргийлэх

бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, хугацаат цэргийн алба хаагчдын ахуй хэрэглэлд ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол явуулж, угааж цэвэрлэх

төдийгүй тэдэнд дархлаа дэмжих витамин, гар ариутгагч, бусад шаардлагатай хэрэгслээр хангаж, шим тэжээлтэй хоол хүнсээр үйлчилж байна.

Ахмад Д.ГАНБААТАР

ЭНЭТХЭГ УЛС 50 МЯНГАН ЦЭРГЭЭ ХЯТАДТАЙ ХИЛЛЭДЭГ ХОЙД ХИЛ РҮҮ БАЙРШУУЛНА

Доктор /Ph.D/, хурандаа Р.ЭНХБОЛД



Энэтхэг Улс БНХАУ-тай хилийн маргаантай Лех, Жошимат, Сахна, Тезпур, Димапур гэсэн газруудын цэргийн хүчийг нэмэгдүүлж, 50 мянган цэргийг шилжүүлэх шийдвэр гаргаад байна. Ингэснээр тус улс Хятадтай хиллэдэг хойд хил дээр 200 мянган цэрэгтэй болж байгаагаас гадна орчин үеийн танк, их буу, тийрэлтэт артиллерийн системийг нэмж татсаар байгаа юм.

ЗҮҮН АЗИЙН ОРНУУД ХАРИУЦСАН ТУСЛАХААР ДАНИАЛ КРИТЕНБРИНК ТОМИЛОГДОНО



АНУ-ын Сенатын гадаад харилцааны байнгын хорооны хурлаар АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын Зүүн Азийн орнууд хариуцсан туслахын албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Даниал Кристенбринкийн сонголт хийгдлээ. АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Байден Зүүн Азийн орнуудад явуулах АНУ-ын гадаад бодлогыг тодорхойлох энэхүү чухал албан тушаалд Д.Кристенбринкийн нэрийг дэвшүүлсэн юм. Тэрээр 2017 оноос хойш АНУ-аас Вьетнам Улсад суугаа Элчин сайдаар ажиллаж байгаа ба Америкийн гадаад харилцааны албанд 27 жил, түүний дотор Азийн

орнуудын асуудлыг 24 жил хариуцан ажиллаж буй туршлагатай дипломатч аж.

Мөн тэрээр өмнө нь Бээжин дэх АНУ-ын Элчин сайдын яаманд ажиллаж байснаас гадна Хойд Солонгостой харьцах АНУ-ын гадаад бодлогыг хариуцаж байв. Хэрвээ тэрээр уг албан тушаалд томилогдвол Зүүн Азийн орнууд болох БНХАУ, Япон, Өмнөд Солонгос, Хойд Солонгос, Тайвань, Хонконг, Монгол, Макао зэрэг оронд АНУ-ын гадаад бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх гол хүн болж хувирах юм.

/Эх сурвалж: scmp.com/

ЦАГ ҮЕ

ЭЦЭГ ЭХЧҮҮД ХҮҮХДЭЭ ВАКЦИНЖУУЛАЛТАД ИДЭВХТЭЙ ХАМРУУЛЖ БАЙНА



Энэ сарын 28-ны өдрөөс эхлэн улсын хэмжээнд 12-15 насны хүүхдийг вакцинжуулах ажил эхэллээ. Тухайн насны хүүхдүүдийг сайн дурын үндсэн дээр Файзер вакцинаар дархлаажуулалтад хамруулж байгаа юм. Хүүхдээ дархлаажуулалтад хамруулахыг хүссэн эцэг эх, асран хамгаалагч нь харьяа дүүргийнхээ дархлаажуулалтын цэгт хамт очиж зөвшөөрлийн хуудас бөглөх шаардлагатай. Өчигдрийн байдлаар хариу урвал, сөрөг үр дүнгийн тохиолдол гараагүй. Харин хоёр хүүхэд өлсөж ухаан алдсан аж. Тухайн хүүхдүүдийн хувьд өглөөнөөс хойш огт цай

хоол идээгүй байсан бөгөөд олон цаг гадаа дугаарлаж зогссоны улмаас ухаан алдсан байна. Хэдийгээр дэлхийн хэмжээнд судалгааны ажлууд дээр үндэслэж вакцин үйлдвэрлэж байгаа ч вакцин 100 хувь дархлаа тогтооно гэдэг нь ташаа мэдээлэл. Монгол Улсад дөрвөн төрлийн вакцин хийж байгаа. Аль ч улсын вакцин хийлгэх нь хувь сонголт хэдий ч хүүхдүүдийн тухайд эцэг эхчүүд ДЭМБ-ын зөвлөмжтэй танилцах нь зүйтэй юм. Хүн бүрийн дархлаа, биеийн байдал харилцан адилгүй учраас үр дүн, хариу урвал ч өөр өөр байх

болно гэдгийг бодолцож, дээрх насны хүүхдээ вакцинд идэвхтэй хамруулахыг уриалах хэрэгтэй. Ингэснээр нийт иргэдийн дунд халдварын тархалт буурах боломжтой гэж ЭМЯ-наас мэдээллээ. Мөн дархлаажуулалтын ачааллаас болоод хамгийн багадаа 3-4 цаг дугаарлан байж вакцинаа хийлгэж байгаа учраас наршихаас сэргийлж малгай өмсөх, бага насны хүүхдээ олон нийтийн газраар авчрахгүй байх, 12 нас хүрэхэд 1-2 сар дутуу байж болохгүй аж. Түүнчлэн вакцин хийлгэхээс өмнө цай ундаа сайн уух хэрэгтэй бөгөөд даарахаас сэргийлэх нь чухал юм.